



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2023 он

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

**БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
(2023 оны жилийн эцсийн байдлаар)**

2023 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

**НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

1.1.Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган 2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт 100%, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 95.0%, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 100%, Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт 90.0 %, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 92.0%, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт 94.0%-ийн биелэлтэй хэрэгжсэн.

Хүснэгтээр үзүүлбэл:



№	Бодлогын баримт бичгийн нэр	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1.	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	1	1	100%
2.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1	2	95.0%
3.	Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	1	1	100%
4.	Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	1	3	90.0%
5.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	5	11	92.0%
6.	Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	1	20	94.0%

1.1.1.Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулах зорилтын хүрээнд:

❖ Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг нэмэгдүүлэх арга хэмжээ

Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг 7 байршилд ажиллуулж үүнээс Нийслэлийн Засаг захиргааны IV байр, “Төв шуудан”, ХБНГУ-ын Фрайбург хот, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудалд байрлах жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг тогтмол, “Тэрэлж Монгол олле”, “Хонхор тосгон Монгол олле”, “Сөүлийн гудамж Монгол олле” төвүүд улирлын чанартай ажиллалаа.

Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд




Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдээр 2023 оны жилийн эцсийн байдлаар 10,741 хүн үйлчлүүлж, "Бүргэдийн баяр", "Дээлтэй Монгол наадам", "Даншиг наадам-Хүрээ цам" арга хэмжээ болон "Улаанбаатар травел экспо" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, "ITM Mongolia-2023" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зэрэг арга хэмжээний үеэр жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн цэгийг ажиллуулж 30,000 гаруй хүн нийт 40,741 гадаад, дотоодын иргэн. жуулчдад мэдээ мэдээлэл зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлсэн.

Жуулчдын санал, хүсэлтийг хүлээн авах, зөвлөгөө, мэдээ мэдээллээр хангах лавлах 118 тусгай дугаарын утсаар 7500 гаруй, жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийн 70108687 утсаар 828 нийт 8328 дуудлага хүлээн авч шаардлагатай мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

- ❖ Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, шинэ аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх арга хэмжээ

- ✓ Жуулчдад зориулсан эвент арга хэмжээ



“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, найрамдалт харилцаат хотуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 2023 онд 17 арга хэмжээг зохион байгуулж 241,000 хүн үзэж сонирхсоноос 13,700 нь гадаадын жуулчин байв. Үүнд:

✓ **“Улаанбаатар өвлийн наадам 2023”**

Улаанбаатар хотод өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн уламжлалт болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Улаанбаатар өвлийн наадам-2023” арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд “Скай ресорт” цогцолборт зохион байгуулж “Мөсөн сурын Монгол туургатны аварга шалгаруулах тэмцээн”, “Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн”, “Параглайдингийн хотын аварга шалгаруулах тэмцээн”, “Рагбигийн хотын аварга шалгаруулах тэмцээн”, “Снөүбоардын параллел слалом тэмцээн” зэрэг 5 төрлийн тэмцээн зохион байгуулж ОХУ-ын Буриад, Тува, Халимаг улсаас 30, БНХАУ-ын ӨМӨЗО-оос 6, Монгол Улсын 21 аймгаас 450, Улаанбаатар хотоос 370 нийт 856 хүн оролцов.

Арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн хананд авирах, мөсөн сур, мөсний шагай, “АХА”, гэр бүлийн буухиа, олс таталтын тэмцээн болон урлагийн тоглолт, орен тис, параглайдингийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр, цана чарга, нохой чарга, хоол ундны үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг нийт 10,000 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчид үзэж сонирхсон.



✓ **“Бүргэдийн баяр”**

“Бүргэдийн баяр-2023” арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 04,05-ны өдрүүдэд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт 13 дахь жилдээ зохион байгуулж бүргэдтэй парад, бүргэдээр шырга (хиймэл өгөөш) бариулах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн, Казак үндэсний тоглоом кекбар (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгуулж Баян-Өлгий, Төв, Сэлэнгэ аймгаас 19 бүргэдчин оролцлоо. Арга хэмжээний үеэр Үндэсний урлагийн их театрын уран бүтээлчдийн тоглолт, “Морьтон баатруудын шоу тоглолт”, “Харцага, шонхор

шувуудын шоу тоглолт”, галын наадам, тойрон бүжиг, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах, 360 камераар зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, арга хэмжээг нийт 10.000 гаруй гадаад, дотоодын иргэд жуулчид үзэж сонирхлоо.



✓ **“Playtime” олон улсын хөгжмийн наадмын урьдчилсан “PRE-EVENT”**

“Playtime” олон улсын хөгжмийн наадмын урьдчилсан “PRE-EVENT” арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, “A dawn is”, “Kade x Grey”, “The shy poopers”, “Vagaband”, “Deaf cats”, “Teresa in the moon” зэрэг 7 хамтлаг уран бүтээлээ хүргэж арга хэмжээг нийт 5000 гаруй хүн үзэж сонирхсон.





✓ “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль

Соёл, шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан арга хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Тэнгэр тайлал” төрийн бус байгууллагатай хамтран “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулж Франц, Польш, АНУ, Канадын уугуул индиан, Бүгд Найрамдах Солонгос Улс, БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Буриад зэрэг 10 улсаас 40, Монгол Улсаас 300 нийт 340 гаруй бөө оролцож нар тахих ёслол, бөөгийн туг сүлд залах ёслол, тэнгэрийн дуудлага зан үйл, гал тахих ёслол болон бөө мөргөлийн зан үйл үзүүллээ. “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль арга хэмжээний үеэр урлагийн тоглолт, морин циркийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр, морьтон баатруудын үзүүлбэр болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, арга хэмжээг нийт 10,000 хүн үзэж сонирхсон.



✓ “UB bike tour” дугуйн аялал

Дэлхийн дугуйн өдрийг тохиолдуулан Монголын дугуйн холбоо, Дугуйтай гэр бүл БНН-тэй хамтран “UB BIKE TOUR” дугуйн анхы аяллыг 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж аяллыг Скай ресортын цанын бааз, Налайх үүрэг, Төв аймгийн Зуунмод хот, Буянт-Ухаа спорт цогцолбор гэсэн 90 км замын маршрутаар зохион байгуулж, дугуйн аялалд “Улаанбаатар”, “Нүүдэлчин”, “Neo cycle mountain bike” зэрэг 10 клубийн 100 гаруй дугуйчид оролцлоо.



✓ **“POWER EXPO & FESTIVAL” экстрим, экспо, энтэртайнмент арга хэмжээ**

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Монголын Мэргэжлийн спорт авто машины холбоо”, “VIP авто клуб”, “VEP энтэртайнмент продакшн”-тай хамтран “POWER EXPO & FESTIVAL” экстрим, экспо, энтэртайнмент арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд Авто худалдааны цогцолбор төвд зохион байгууллаа.



Арга хэмжээг үндсэн 3 хэсгээс буюу EXTREME-хэсэгт мэргэжлийн болон сонирхогчдын ангиллаар зохион байгуулагдсан DRIFT тэмцээнд нийт 68 тамирчин оролцон шилдгүүдээ тодруулж, мөн мото, спорт төрлийн авто машин, мотоциклийн парад, мэргэжлийн мото, авто клубүүдийн үзүүлбэрүүд явагдаж, EXPO-хэсэгт орчин үеийн болон ховор нандин мото, спорт авто машин, мотоциклийн үзэсгэлэн, худалдаа болон дагалдах хэрэгслийн худалдаа, үйлчилгээ зохион байгуулагдаж нийт 120 гаруй аж ахуйн нэгж байгууллага оролцож мөн хөдөлгөөнт хэрэгслийн хөгжлийг дэмжих хэлэлцүүлэг, гар зургийн уралдаан, хувцас загварын үзүүлбэрүүд зохион байгуулагдаж, ENTERTAINMENT-хэсэгт гадаад, дотоодын хамтлаг, уран бүтээлчдийн нэгдсэн хөгжмийн хөтөлбөрт The Hu,

Niciton, Nisvanis, Bulsara, Erka, Thunder, Desant, Babar зэрэг 50 гаруй хамтлаг, дуучид, уран бүтээлчид оролцож арга хэмжээг нийт 25,000 гаруй хүн үзэж сонирхлоо.



✓ **“Талын салхи” олон улсын мото наадам**

Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн шинэлэг хотын аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор “Чингис MC” мото клубтэй хамтран “Талын салхи” олон улсын мото наадмыг 7 дахь жилдээ 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбай болон “Чингис хааны хүрээ” цогцолборт зохион байгуулж, оролцогчид Сүхбаатарын талбайгаас баруун 4 зам, “Тэнгис” кино театр, сансрын туннел, зүүн 4 зам, 120 мянгат, “Буянт-Ухаа”, Чингисийн хүрээ цогцолбор хүртэлх маршрутаар нийт 28.2 км мото парад зохион байгуулж, парадад ОХУ-аас 200, БНХАУ-аас 70, БНСУ-аас 10, Монгол Улсаас Улаанбаатар хот 21 аймгийн 45 клубийн 1700 гаруй нийт 2000 гаруй мотоцикл сонирхогчид оролцлоо.

Арга хэмжээний үеэр мото түүний дагалдах хэрэгслийн үзэсгэлэн худалдаа, ховор нандин мотоциклын үзүүлэн танилцуулга, оролцогчдын дунд олс таталт, гар барилдааны тэмцээн, соёл урлагийн тоглолт зохион байгуулж арга хэмжээг 7000 гаруй хүн үзэж сонирхлоо.



✓ “Плэйтийм 2023” олон улсын хөгжмийн наадам

Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг дэлхий нийтэд сурталчлах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Амьд хөгжмийн наадам” ТББ-тай хамтран “Плэйтийм-2023” олон улсын хөгжмийн наадмыг 2023 оны 07 дугаар сарын 06,07-ны өдрүүдэд “Монгол шилтгээн цогцолбор”-т 21 дэх жилдээ зохион байгууллаа.

“Плэйтийм-2023” олон улсын хөгжмийн наадамд АНУ-ын “Cigarettes After Sex”, БНХАУ-ын инди рок “Carsick Cars”, ОХУ-ын “Shortparis”, “Motorama”, “The KVB”, БНСУ-ын “Idiotape” зэрэг гадаадын 63 уран бүтээлч, Монгол Улсаас “Niciton”, “Delkhii”, “Nisvanis”, “Bulsara”, “Growl Of Clown”, “The Colors”, “A dawn is”, “Kade x Grey”, “The shy poopers”, “Vagaband”, “Deaf cats”, “Teresa in the moon” болон дуучин Ариунаа, Сарантуяа, Минжинсор, Чойжоо, Баатар зэрэг 673 уран бүтээлч нийт гадаад дотоодын 736 хамтлаг, дуучид 2 өдрийн турш уран бүтээлээ хүргэж арга хэмжээг эхний өдөр 22,000 хүн, хоёр дахь өдөр 27,000 хүн нийт 49,000 гаруй хүн үзэж сонирхов.

Наадмын үеэр болон бэлтгэл ажилд 3000 гаруй түр ажлын байр бий болгож, худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэлд 150 гаруй аж ахуй нэгж, байгууллага үйлчилгээ үзүүлээ.





✓ “Дээлтэй Монгол наадам 2023”

Монголчуудын уламжлалт өв соёл, үндэсний хувцасны язгуур хэв шинж, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Үндэсний хувцасны өдөр “Дээлтэй Монгол наадам-2023” арга хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, баярын жагсаалд Монгол туургатан БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа аймаг, Хөх нуурын Дээд Монголчууд, ОХУ-ын Буриад, Тува зэрэг улсаас 269 хүн, 21 аймаг, нийслэлийн 6 дүүрэг болон 30 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 8348 нийт 8617 хүн оролцсон.

Арга хэмжээнд оролцогчдоос шилдэг дүүрэг, шилдэг байгууллага, шилдэг бүжгийн оролцогч, шилдэг дээл урлаач, гадаадын шилдэг эрэгтэй, эмэгтэй оролцогч, хамгийн сайхан дээлтэй хүүхэд зэрэг 10 номинациар шилдгүүдийг тодруулав.

Мөн арга хэмжээний үеэр урлагийн тоглолт, үндэсний хувцасны загварын шоу үзүүлбэр, дээлтэй диско, морьтон баатруудын парад зэрэг арга хэмжээ, 6 дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 168 иргэн, аж ахуй нэгж, байгууллага 40 асарт үндэсний дээл хувцас, эд хэрэглэлийн худалдаа үйлчилгээ зохион байгуулж арга хэмжээ нийт 15,000 гаруй хүн үзэж сонирхлоо.





✓ Монголчуудын өв соёлын “Даншиг наадам-Хүрээ цам 2023”

Монголчуудын уламжлалт өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор Монголчуудын өв соёлын “Даншиг наадам-Хүрээ цам 2023” арга хэмжээг “City of nomads” уриа дор Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран 2023 оны 08 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд Хүй 7 худагт зохион байгуулж арга хэмжээний үеэр Үндэсний 256 бөх, Буриад 64 бөх, Өвөр-Монгол 64 бөхийн барилдаан болон их нас, хязаалан, жороо морьдын уралдаан, морьт харвааны тэмцээн, сээр цохих тэмцээн, уухай шагайн харвааны тойром, үндэсний сур харвааны тэмцээн, “Хүрээ цам-Майдар” түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн, Монгол үндэсний таван тансаг идээ цайны үзэсгэлэн, Монгол хувцасны үзүүлбэр, Монгол туургатан улсуудын урлаг соёлын “Сити оф номадс” шоу тоглолтоос гадна “Нүүдэлчдийн Нийслэл” эрдэм шинжилгээний хурал болж 9 орны 50 монгол судлаач, түүхч эрдэмтэд Монгол улсын өнө эртний түүх, эрт дээр үеэс уламжлагдан ирсэн өв соёлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа.



Арга хэмжээний үеэр Гандантэгчэнлин хийдийн лам хуврагууд хүрээ цам харайх ёслол, “Очирваань” бурхны тахилга, Эзэн Богд Чингис хааны тахилга үйлдэж, лам нарын дунд ном хэлэлцэх, мэтгэлцэх, балин тосон урлал, хурал номын ая эгшиг унзад голч нарын тэмцээн тус тус зохион байгуулагдав.

“Даншиг наадам-Хүрээ цам 2023” арга хэмжээнд Буриад, Халимаг Тува, Өвөр-Монгол зэрэг Монгол туургатан улсуудаас 56 хүчит бөх, урлаг, соёлын 20 уран бүтээлч оролцож, Монгол Улсад суугаа 24 элчин сайдын яамны 72 зочид төлөөлөгчид, 3700 орчим жуулчид, дотоодын 50.000 гаруй иргэд үзэж сонирхсон.



✓ “UB food festival 2023”

Монгол үндэсний хоол болон олон үндэсний хоолны соёлыг гадаад, дотоодын иргэд, жуулчдад таниулах, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “UB FOOD FESTIVAL-2023” арга хэмжээг 9 дэх жилдээ жанжин Д.Сүхбаатарын талбайд 2023 оны 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Фестивальд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний “Туул гардан”, “Хөх үүр айраг, зоог”, “Bегan” хоолны ресторан, “Хулан”, “Mind food studio”, “Namaste Indian Restaurant”, “Хаш таг (Broadway)”, “Vesper”, “Whall street”, “Hardrock”, “Art ger- boodog boys”, “Nagomi Restaurant”, “Том Н Томс” кофе шоп, Томоко ХХК - Зөгийн бал зэрэг 40 гаруй ресторан, зоогийн газар, кофе шопын байгууллагууд Монгол, Хятад, Япон, Солонгос, Энэтхэг, Тайланд, Европ үндэсний хоол, зууш болон кофе, амттанаар үйлчилгээ үзүүллээ.

Монголын тогооч нарын холбооны мастер тогооч нар хоолны шоу үзүүлбэр буюу битүү утаж шарсан хонь, утаж шарсан гахай, 10 метр урт сэндвич хийж үзэгчдэд амтлуулж, оролцогч байгууллага “Whall street”, “Namaste Indian Restaurant” ресторонууд хоолны үзүүлбэр, “Хулан” ресторан бартендерийн үзүүлбэр, “Vesper”, “Broadway” ресторонууд

коктейлийн үзүүлбэр үзүүлэв. “UB FOOD FESTIVAL-2023” арга хэмжээний үеэр хүүхдүүдийн дунд зайрмаг хурдан идэх тэмцээн, эрэгтэй, эмэгтэйчүүдийн дунд хоол хурдан идэх тэмцээн, дэмбээний тэмцээн тус тус зохион байгуулж, хүүхэд багачуудад хүүхдийн кино, ном зохиолын үлгэрийн баатрын үзүүлбэр үзүүлж, мөн 3 өдрийн турш open mik, уран бүтээлчдийн тоглолт, DJ, жааз хөгжим, амьд хөгжмийн хамтлагын тоглолт зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын 20,000 гаруй хүн үзэж сонирхлоо.



✓ “ULAANBAATAR walking festival 2023”

Монгол Улсыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Улаанбаатар хот орчмын түүх соёл, өв уламжлал, ахуй байдал, байгалийн үзэсгэлэнт газруудыг сурталчлан таниулах зорилгоор “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль 2023” (Ulaanbaatar Walking Festival) арга хэмжээг Монголын явган алхалтын холбоо, “Монгол Оллэ” нийгэмлэгтэй хамтран 2023 оны 08 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Фестивальд Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон, БНХУ-ийн (Тайвань Улс), Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд найрамдах Чех Улс, Австрали зэрэг улсуудаас 140 гаруй алхагчид, Монголын явган алхалтын холбооны салбар байгууллагуудын төлөөлөл Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Хэнтий,

Сэлэнгэ, Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл, Увс, Төв зэрэг аймгууд болон нийслэлийн дүүргүүдийн төлөөлөл нийт 400 гаруй алхагчид 3 өдрийн явган алхалтын тохижуулсан туршид “Монгол олле” 1, 2, 3 дугаар маршрутаар нийт 41,8 км замаар аялал хийв.



✓ **“Хийморь” олон улсын морьт харвааны тэмцээн болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээн**

Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, үндэсний өв уламжлалаар дамжуулан жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох зорилгоор Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Олон улсын морьт харвааны холбоо “ИНАА”, Монголын Морьт харваачдын холбоо хамтран “Хийморь” олон улсын морьт харвааны тэмцээн болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 01-10-ны өдрүүдэд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа. “Хийморь” олон улсын морьт харвааны тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 01-03-ны өдрүүдэд зохион байгуулж Монгол, АНУ, ОХУ, БНХАУ, Өмнөд Африк, Ирланд, Япон зэрэг 11 улсын 102 морьт харваачид 4 төрлөөр өрсөлдлөө.

Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 07-10-ны өдрүүдэд зохион байгуулж АНУ, ОХУ, БНХАУ, БНСУ, ХБГУ, Франц, Австрали, Өмнөд Африк, Канад, Унгар, Монгол зэрэг дэлхийн 19 орны 88 тамирчид мастер, насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үе гэсэн ангиллаар “Скермиш” буюу түрэг харваа, “Рэйд” буюу Ази харваа, “Тавер” буюу Унгар харваа, “Хантинг”, “Монгол бөмбөг намнаа” гэсэн 5 төрлөөр өрсөлдөж “ИНАА” буюу олон улсын морьт харвааны холбооны дүрмээр зохион байгуулагдаж нийт дүнгээр Франц улсын баг тамирчид тэргүүн байр, Монгол улсын баг тамирчид 2 дугаар байр, Казакстан улсын баг тамирчид 3 дугаар байр эзэлсэн. Арга хэмжээний үеэр урлагийн тоглолт, морин циркийн үзүүлбэр, морьтон баатруудын үзүүлбэр зохион байгуулагдаж арга хэмжээг нийт 5000 гаруй хүн үзэж, МҮОНРТ-ийн Спорт сувгаар шууд дамжуулав.



❖ **Найрамдалт харилцаат хотуудын аялал жуулчлал, соёл урлагийн өдрүүдийг зохион байгуулах арга хэмжээ**

✓ **"Франц хэлтнүүдийн хотхон" соёл, аялал жуулчлалын өдөрлөг**

Франц хэлтэн орнуудын хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор Монгол-Францын соёлын төвтэй хамтран "Франц хэлтнүүдийн хотхон" соёл, аялал жуулчлалын өдөрлөгийг 24 дэх жилдээ 2023 оны 03 дугаар сарын 26-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр Франц хэлээр үйл ажиллагаагаа явуулдаг дипломат байгууллага, боловсрол, соёл, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний 40 байгууллага үйл ажиллагаагаа танилцуулж, Франц улсад суралцах, аялах талаар мэдээлэл өгч, соёл, урлагийн тоглолт, хоол үйлчилгээ зэрэг олон төрлийн арга хэмжээ зохион байгуулагдаж 5000 гаруй хүн үзэж сонирхсон.



✓ “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд”

Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” (Korea Week) арга хэмжээг 2023 оны 08 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд 3 өдрийн турш зохион байгуулж Бүгд Найрамдах Солонгос Улсын нэгдсэн эмнэлэг, арьс, гоо засал, эмэгтэйчүүд, шүд, эрүү нүүр, нүдний эмнэлэг зэрэг эрүүл мэнд болон эрүүл мэндийн аялал жуулчлалын 50 гаруй байгууллага үйл ажиллагаагаа танилцуулж, мөн солонгосын аялал жуулчлал, боловсрол, хүнс, хөдөө аж ахуйн үзэсгэлэн, худалдаа зохион байгуулагдаж 19 аж ахуйн нэгж, байгууллага оролцлоо.

БНСУ-аас урлаг соёлын 100 гаруй уран бүтээлчид, 20 гаруй тамирчид оролцож БНСУ-ын Урлагийн их сургуулийн дэвүүрт бүжиг, Хойд Жолла мужийн “Нанта” үзүүлбэр, Солонгосын уламжлалт хөгжмийн үзүүлбэр, “Бибимбаб” хоолны үзүүлбэр, “Жонбук Ариранг” тоглолт, Монгол, Солонгос оркестрын тоглолт, “Күггивон Таэквондо” үзүүлбэр, “MEGAMAX” хамтлагийн тоглолтыг зохион байгуулж арга хэмжээг нийт 25,000 гаруй хүн үзэж сонирхсон.



✓ Япон соёл, аялал жуулчлалын өдөрлөг

Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, “Лэтс Травел” ХХК-тай хамтран “Япон соёл, аялал жуулчлалын өдөрлөг 2023” (Japan festival) арга хэмжээг 11 дэх жилдээ 2023 оны 09 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж арга хэмжээний үеэр Япон бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, боловсролын үзэсгэлэн, хоолны амталгаа, худалдаа зохион байгуулагдаж 30 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаагаа танилцууллаа.

Япон улсаас 170 гаруй зочид төлөөлөгчид, урлаг соёлын 80 гаруй уран бүтээлчид оролцож Япон үндэсний хөгжмийн Этосэтора хамтлагийн тоглолт, Япон косплэй хувцасны үзүүлбэр, Япон орныг хэн сайн мэдэх вэ? асуулт хариултын тэмцээн, Япон дуу хэн сайн дуулах вэ? дууны тэмцээн зохион байгуулагдаж арга хэмжээг 5000 гаруй хүн үзэж сонирхсон.



✓ Хятадын улсын соёл, аялал жуулчлалын өдөрлөг

Соёлын яам, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран "Дэлхий далайг холбох тэргэл сар–Тэргэл сарны баяр" Монгол-Хятадын хүндэтгэлийн тоглолтыг 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд БНХАУ-аас 50 гаруй уран бүтээлчид оролцож тоглолтыг 500 гаруй хүн үзэн сонирхсон.



Мөн Улаанбаатар дахь Хятадын соёлын төвөөс "Монгол-Хятадын аялал жуулчлалын семинар"-ийг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж БНХАУ-ын зах зээлд үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын 50 гаруй тур оператор компанийн төлөөллүүд оролцлоо.



✓ **Аялал шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ “Орижин” шоу тоглолт**



Жуулчдад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээ, арга хэмжээний тоог нэмэгдүүлэх зорилгоор “Хүрээ Энтертайнмент” ХХК-аас санаачлан орчин үеийн техникийн дэвшилтэт шийдэл Immersive projection mapping буюу 360 градусаар цацруулагч проектор дээр суурилсан дүрст үзүүлбэрийг Ардын язгуур урлагтай хослуулсан “Орижин” шоу тоглолт, үйлчилгээг танилцуулах арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж арга хэмжээнд аялал жуулчлалын 80 гаруй тур оператор компани оролцлоо.



1.1.2. Аялал жуулчлалын салбарт инновацийг нэвтрүүлж, гадаад дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа маркетингийн ажлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

❖ **Улаанбаатар хотын танилцуулга сэтгүүл, цахим сэтгүүл, газрын зураг, хөтөч ном зэрэг тараах материал шинэчлэн гаргах арга хэмжээ**

Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл 9000 ширхэг, (Англи, Солонгос, Япон, Герман, Орос, Хятад хэлээр), Улаанбаатар хотын хөтөч ном 1500 ширхэг (Англи хэлээр), Улаанбаатар хотын газрын зураг 5000 ширхэг нийт 15,500 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, эвент арга хэмжээнүүдэд тарааж Улаанбаатар хотыг сурталчлан ажилласан.



❖ **Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны конент бэлтгэж, гадаад, дотоодод түгээн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ**

“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын олон нийтийн сүлжээгээр болон дэлхийд алдартай аялагч нараар дамжуулан Улаанбаатар хотыг сурталчлах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа.Үүнд:

✓ **Улаанбаатар хотын аяллын тухай танилцуулга, нэвтрүүлэг**

Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын аяллын тухай танилцуулга, нэвтрүүлэг хийх ажлыг Оросын Холбооны Улсын Красноярск хязгаарын "Красноярск" телевиз, радиогийн улсын байгууллагатай хамтран 2023 оны 05 дугаар сарын 04-08-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Нэвтрүүлгийн зураг авалтыг Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Хустайн нурууны байгалийн цогцолборт газар, “Чингис хааны хөшөөт цогцолбор”, “Чингис хааны Үндэсний музей”, “Зайсан толгой- зөвлөлтийн дайчдын хөшөө”, “Бурхан буддагийн цэцэрлэгт хүрээлэн”, “Гандантэгчилэн хийд” зэрэг газруудад болон Монголын үндэсний урлаг, хоол, идээ ундаа, ноос ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар зураг авалт хийх нэвтрүүлгийг ОХУ-ын 2 телевизээр түгээсэн.



✓ **“The Amazing Race Israel” телевизийн шоу нэвтрүүлэг**

Израил Улсын “The Amazing Race Israel” телевизийн шоу нэвтрүүлэг нь дэлхийн 60 гаруй улсад хийгдсэн бөгөөд ээлжит цуврал контентыг “Keshet broadcasting Ltd” “Титэм говь” ХХК-тай хамтран 2023 оны 05 дугаар сарын 21-29-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа.

Шоу нэвтрүүлэгт оролцогч Израил Улсын 7 хос 14 оролцогч Сүхбаатарын талбай, “Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газар”, “Чингис хааны хөшөөт цогцолбор”, “Чингис хааны Үндэсний музей”, “Зайсан толгой-зөвлөлтийн дайчдын хөшөө”, “Гандантэгчилэн хийд” зэрэг газруудаар орж даалгавар гүйцэтгэж, нэвтрүүлгийг олон нийтийн сүлжээгээр 15 гаруй сая хүн үзсэн байна.



✓ “Улаанбаатарын үдэш” дуу

БНХАУ-аас зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатарын үдэш” дууг (хятад хэл) дуулж 250 сая гаруй хүнд хүргэсэн БНХАУ-ын “Чинхай” мужийн “Гүйнань” хотын ээж хүү хоёр уран бүтээлч Гензанг Жуама, Данжен нарыг урьж дууны клипний зураг авалтыг 2023 оны 09 дүгээр сард зохион байгуулсан.

Дуучдыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч нар хүлээн авч уулзсан бөгөөд тэднийг Улаанбаатар хотод ирсэн тухай мэдээлэл БНХАУ-ын цахим орчинд цацагдсан даруйд 70 сая гаруй хүнд хүрээд байна.



✓ Эвент арга хэмжээний контент

Улаанбаатар хотын аялал жуулчлалын тухай 2 контент “Улаанбаатар өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Хийморь” морьт харвааны наадам “Улаанбаатар олон улсын хоолны фестиваль” зэрэг эвент арга хэмжээнүүдийн талаарх богино хэмжээний 5 контент нийт 7 контент хийж үйл ажиллагаа сурталчилсан.



❖ Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор олон улсын арга хэмжээнд оролцох, зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ

Улаанбаатар хот Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоонд (World Tourism Cities Federation) 2022 онд элссэн бөгөөд Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор 2023 онд Гадаад харилцааны яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Монголын Аялал жуулчлалын холбоо, олон улсын байгууллагууд, тур оператор компаниудтай хамтран олон улсын 8 үзэсгэлэн арга хэмжээнд оролцож, 5 үзэсгэлэн арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

Оролцсон олон улсын арга хэмжээ

✓ “Messe Stuttgart CMT 2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

ХБНГУ-ын Штуттгарт хотод 2023 оны 01 дүгээр сарын 13-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Messe Stuttgart CMT-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол Улс түнш орноор оролцож байгаатай холбоотойгоор Улаанбаатар хотыг сурталчлах, ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Туурайн төвөргөөн” ТББ-тай хамтран жуулчны мэдээлэл, сурталчилгааны цэгийг ажиллуулж “Ulaanbaatar your gateway”, “Ulaanbaatar official visitors guidebook” сурталчилгааны 300 ширхэг тараах материалыг үзэсгэлэнд оролцогчид, жуулчид, тур операторуудад түгээн сурталчилсан.



✓ “ITB Berlin 2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

ХБНГУ-ын Берлин хотод 2023 оны 03 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “ITB Berlin 2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн “Өөрчлөлтөд нээлттэй” сэдвийн дор зохион байгуулагдаж дэлхийн 165 орны 5500 төлөөлөгчид оролцож, үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулагдсан 200 хуралд 400 гаруй илтгэгч “Аялал жуулчлалын салбарын тогтвортой байдал”, “Зочид буудлын үйл ажиллагааг оновчтой болгох нь”, “Эрүүл мэнд, эмчилгээний аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх нь” сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлэн, B2B уулзалтууд зохион байгуулагдлаа.

“ITB Berlin-2023” үзэсгэлэнд Монголын Аялал жуулчлалын холбоо болон 11 тур оператор байгууллага оролцсон бөгөөд арга хэмжээний үеэр Улаанбаатар хотын сурталчилгааны “Ulaanbaatar your gateway” (герман хэл) сэтгүүлийг оролцогч нарт 300 ширхгийг тарааж сурталчилсан.



✓ **Монгол-Хятад 2 Улсын аялал жуулчлалын зөвлөлийн уулзалт**

БНХАУ-ын Манжуур хотод зохион байгуулагдсан Монгол-Хятад Улсын аялал жуулчлалын зөвлөлийн тур оператор компаниудын уулзалтад Нийслэлийн аялал жуулчлалын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга В.Батчимэгээр ахлуулсан 20 гаруй төлөөлөгчид 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд Манжуур хотод ажиллаа.

Манжуур хотын Соёл, спорт, аялал жуулчлал, радио телевизийн газрын удирдлага холбогдох албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулж, уулзалтын үеэр Улаанбаатар хотод 2023 онд зохион байгуулагдах олон улсын шинж чанартай томоохон арга хэмжээнүүдийн талаар танилцуулга хийж, Манжуур хотоос тусгай сонирхлын жуулчид хүлээн авах талаар ярилцаж, 2 улсын тур оператор компаниуд B2B уулзалт зохион байгуулж цаашид хамтран ажиллах гэрээ байгуулав.



✓ **“SITF 2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн**

Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод 2023 оны 05 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд 38 дахь жилдээ зохион байгуулагдсан (SITF) “Сөүл” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд дэлхийн 70 гаруй улс оролцлоо.

Монгол Улсаас БНСУ-д Монгол Улсаас суугаа Элчин сайдын яам, нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Аялал жуулчлалын холбоо болон “Let’s Travel”, “UVS”, “Parusa тур”, “Mongolian vision tours”, “Authentic Tours”, “Birgatour, Great Mongolia Tour”, “Zaya Travel” зэрэг 8 тур оператор компани оролцож “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчиллаа. Мөн үзэсгэлэнгийн үеэр “Аялал жуулчлалын салбарын сэргэлт, дижитал шилжилт, инноваци ба аялал жуулчлалын өсөлт” сэдвүүдийн хүрээнд зохион байгуулагдсан форум, хэлэлцүүлэгт 13 орны 500 зочид төлөөлөгчид оролцсон.





✓ **“Чанша анхилам уулс аялал жуулчлалын дээд хэмжээний чуулга уулзалт”**

Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбооноос Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хунань мужийн Чанша хотод 2023 оны 05 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд зохион байгуулсан “Чанша анхилам уулс аялал жуулчлалын дээд хэмжээний чуулга уулзалт” арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх нар оролцсон.

“Чанша анхилам уулс аялал жуулчлалын дээд хэмжээний чуулга уулзалт”-д БНХАУ-д суугаа 8 Улсын Элчин сайд, 37 улсын WTCF-ийн хот, муж, байгууллагуудын гишүүд болон дэлхийн аялал жуулчлалын томоохон аж ахуйн нэгжүүдийн 400 гаруй төлөөлөгчид оролцож арга хэмжээний үеэр Улаанбаатар хот Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоонд элссэн батламжаа авлаа.

Уулзалтаар Аялал жуулчлалын сэргэлт, Сорилт ба хамтын ажиллагаа, Хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ аргачлал илтгэлүүд, 2023 оны аялал жуулчлалын эдийн засгийн чиг хандлага, Дэлхийн хотуудын Ковид цар тахлын нөхцөл дэх тогтвортой хөгжлийн тайланг хэлэлцэж, хөрөнгө оруулалтыг дэмжих хурал, B2B уулзалт зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа.



✓ **“Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Олон улсын эдийн засаг худалдаа хөрөнгө оруулалтын Эрээн хот чуулга уулзалт ба үзэсгэлэн худалдаа”**

Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорын зам дагуух бүс нутгуудын нөхөрсөг хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод 2023 оны 08 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Олон улсын эдийн засаг худалдаа хөрөнгө оруулалтын Эрээн хот чуулга уулзалт ба үзэсгэлэн худалдаа 2023” арга хэмжээнд Монголын Аялал жуулчлалын холбоо, 6 тур оператор компанийн төлөөлөлтэй хамтран оролцлоо.

Чуулга уулзалт нь боломжийг хуваалцах, хамтаар хөгжих, цэцэглэлтийг ахиулах сэдвээр бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, эдийн засгийн форум, төсөл хөтөлбөр солилцох гэх зэрэг арга хэмжээний хүрээнд зохиогдож Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга В.Батчимэг Улаанбаатар хотын аялал жуулчлал цайны замын брэнд авто аялал сэдвээр илтгэл танилцуулав.



✓ **“Цайны зам” олон улсын соёл, аялал жуулчлалын хурал**


Цайны замын олон улсын холбооноос Бүгд Найрамдах Хятад Ардын Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Хөх хотод 2023 оны 09 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулсан “Цайны зам” олон улсын соёл, аялал жуулчлалын хуралд Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх нар оролцоо.

Хуралд БНХАУ-аас 200, ОХУ-аас 45, Монгол Улсаас 20 гаруй нийт 265 төлөөлөгчид оролцож Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх Улаанбаатар хотын аялал жуулчлалын талаар танилцуулж, авто аялал болон эвент арга хэмжээг зохион байгуулах, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар санал солилцлоо.



Мөн Монгол, БНХАУ, ОХУ гурван улс дамнасан Цайны зам аялал жуулчлалын брэндийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хотод “Жуулчин төгөл” төслийг

хамтран хэрэгжүүлэх зорилгоор БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотын Засаг захиргааны Гадаад харилцааны албаны дарга Хоу Жихуй, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотын Намын байнгын хорооны гишүүн, хотын даргын орлогч Жанг Фифэйтэй тэргүүтэй хүмүүстэй албан уулзалт зохион байгуулж “Жуулчин төгөл” төслийг хамтран хэрэгжүүлэхээр санал солилцлоо.




✓ “JATA 2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Монгол улс, Улаанбаатар хотыг сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Япон Улсын Осака хотод “Ирээдүй хаалгыг нээцгээе” уриа дор “JATA-2023” (Tourism Expo Japan) олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2023 оны 10 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж дэлхий 70 улсын 1275 аялал жуулчлалын тур оператор компани, аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгч нар оролцлоо.

Үзэсгэлэнд Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яам, Жайка олон улсын төслийн байгууллагын дэмжлэгтэйгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “МИАТ” ХК болон “Juulchin”, “New Juulchin Tours”, “Lets travel”, “Shine zuuch travel”, “Jiguur”, “Iris tour”, “Best nomadic”, “Weyo travel”, “Jamo tour”, “Altantour”, “Amicus Travel Mongolia” зэрэг 14 тур оператор компани, Өмнөговь аймгийн “Гайхамшигт говь” аялал жуулчлалын холбоо түүний харьяа 10 жуулчны бааз оролцож үйл ажиллагаа сурталчлан танилцууллаа.



Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 2 албан хаагч оролцож Улаанбаатар хотод 2024 онд зохион байгуулагдах эвент арга хэмжээний видео танилцуулгыг хүргэж, Улаанбаатар хотын сурталчилгааны 200 ширхэг сэтгүүлийг (япон хэлээр хэвлэгдсэн) оролцогч нарт тарааж, 2 өдрийн үндэсний урлагийн тоглолтыг хариуцан зохион байгуулж үйл ажиллагаагаа сурталчлан үзэсгэлэнг 4 өдрийн турш нийт 148,050 хүн үзэж сонирхсон.



Зохион байгуулсан олон улсын арга хэмжээ

✓ **“Монгол-Оросын тур оператор компаниудын форум”**

Монголд зочлох жил”-ийн хүрээнд хөрш орнуудын аялал жуулчлалыг хөгжүүлэх, 2023 онд Оросын Холбооны Улсаас 200-250 мянган жуулчин хүлээн авах зорилгоор “Монгол-Оросын тур оператор компаниудын форум уулзалт, танилцах аялал”-ыг 2023 оны 02 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгуулж форумд Оросын Холбооны Улсын 27 бүс нутгаас 100 тур оператор компани, 35 хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл, Монгол Улсаас 106 тур оператор компани нийт 200 гаруй төлөөлөгчид оролцож оролцогчдын дунд бизнесийн гэрээ хэлцэл хийх, харилцан мэдээлэл солилцох B2B уулзалтууд зохион байгуулагдлаа. Форумын үеэр Оросын Холбооны Улсын 35 хэвлэл, мэдээллийн байгууллага, 20 тур оператор компанийн нийт 70 гаруй төлөөлөл хотын аялалд хамрагдаж Улаанбаатар хоттой танилцлаа.



✓ **“Монгол-Солонгосын тур оператор компаниудын форум”**

БНСУ-аас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ, “КТАС” БНСУ-ын жижиг, дунд аялал жуулчлалын холбоо, Монголын солонгосын зах зээлийн аялал жуулчлалын холбоотой хамтран “Монгол-Солонгосын аялал жуулчлалын тур операторуудын форум”-ыг 2023 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж БНСУ-ын аялал жуулчлалын 90 тур оператор компани, Монгол Улсын 110 тур оператор компани нийт 200 тур оператор компаниуд оролцож B2B уулзалтууд зохион байгуулагдав.

Форумын үеэр “Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, чиг хандлага”, “Солонгос жуулчдын зан чанар, онцлог” сэдвүүдийн хүрээнд илтгэл, хэлэлцүүлэг явагдаж, нийслэлийн Аялал жуулчлалын газраас Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны видео танилцуулга хийлээ.



✓ **Цайны замын олон улсын аялал жуулчлалын холбооны гишүүн муж, аймаг, хотуудын уулзалт**

Цайны замын олон улсын аялал жуулчлалын холбооны гишүүн муж, аймаг, хотуудын уулзалтыг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр “IBES” зочид буудлын хурлын таннхид зохион байгуулав.

Уулзалтад БНХАУ-ын ӨМӨЗО-ны Соёл, аялал жуулчлалын танхимын орлогч дарга Жан Вэнь Жүнь, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Аялал жуулчлалын сайд Д.А.Жангарович, Манжуур хотын Засаг даргын орлогч Гө Шяофан, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Т.Мөнх-Од, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх болон Өмнөговь, Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр, Төв зэрэг гишүүн аймгуудын төлөөлөл болон Монгол Улс, БНХАУ, ОХУ-ны аялал жуулчлалын тур оператор компани, бизнес эрхлэгчдийн нийт 70 гаруй зочид, төлөөлөгчид оролцож, “Улаанбаатар хотын аялал жуулчлал”, “Цайны замын аяллын маршрут”, “Цайны зам дагуух авто аялал”, “Боловсрол болон хүүхдийн аялал” сэдвүүдийн хүрээнд танилцуулга мэдээлэл хийгдлээ. Арга хэмжээний үеэр цайны замын дагуу Монгол Улс, БНХАУ, ОХУ-ыг холбосон маршрутаар

авто, мото аялал болон хүүхдийн аялал зохион байгуулах, аяллын шинэ брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор 3 улсын 12 тур оператор компани хамтран ажиллах гэрээ байгууллаа.



✓ **"Улаанбаатар травел экспо 2023" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн**

Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран "Улаанбаатар травел экспо 2023" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд 2023 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд 9 дэх жилдээ амжилттай зохион байгуулав.

Үзэсгэлэн анх удаагаа олон улсын шинж чанартай буюу Цайны замын олон улсын аялал жуулчлалын холбооны хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Аялал жуулчлалын танхим, Манжуур хот, Эрээн хот, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад улс болон БНСУ-ын "Korea Tourism Organization"-ын 30, Монгол Улсаас 150 буюу 4 улсын нийт 180 гаруй байгууллага, аялал жуулчлалын тур оператор компани, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид аяллын дагалдах хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаагаа танилцуулж, үзэсгэлэнг нийт 7000 гаруй хүн үзэж сонирхсон.

Нийслэлийн Аялал жуулчлалын газраас жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг ажиллуулж "Монгол-олле" явган аяллын маршрут, "Visit ulaanbaatar" брэнд бүтээгдэхүүн,

Улаанбаатар хотын автобустай аялал болон 2023 онд зохион байгуулагдах эвент арга хэмжээнүүдийн талаар танилцуулж, 4 төрлийн 1000 ширхэг Улаанбаатар хотын сурталчилгааны материал тараан 1500 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээлэл өгч үйл ажиллагаа сурталчлан ажиллаа.



✓ “ITM Mongolia 2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Дэлхийн аялал жуулчлалын чиг хандлагатай уялдуулан бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, шинэ үеийн хөгжлийн бодлогыг таниулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “Ногоон хөрөнгө оруулалт-бидний ирээдүй” уриа дор “ITM Mongolia-2023” (International Travel Mart) олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 2023 оны 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд 24 дэх жилдээ зохион байгууллаа.

Үзэсгэлэнд 21 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аялал жуулчлалын холбоод болон үндэсний нислэгийн авиа компани, гадаад дотоодын аялал жуулчлалын тур оператор компани, жуулчны бааз, ресторан зоогийн газар, аяллын хэрэгсэл ханган нийлүүлэгч, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэгч, урлаг соёл, үзвэр үйлчилгээний 200 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан танилцуулж, үзэсгэлэнг 13,500 гаруй хүн үзэж сонирхсон.

Нийслэлийн Аялал жуулчлалын газраас жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг ажиллуулж Улаанбаатар хотод зохион байгуулагддаг эвент арга хэмжээ, Visitulaanbaatar цахим хуудас болон хотын аяллын талаар 1200 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ, мэдээллийг хүргэж, Улаанбаатар хотын сурталчилгааны 20 гаруй төрлийн 1570 ширхэг сурталчилгааны материал тарааж үйл ажиллагаагаа сурталчлан ажиллалаа.



1.1.3. Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах зорилтын хүрээнд:

- ❖ Жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ
- ✓ “Оюутан цагдаа-2023” арга хэмжээ

Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, оюутан залуусыг түр ажлын байраар хангаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Оюутан цагдаа-2023” арга хэмжээг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой

хамтран 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хооронд 2 сарын хугацаанд хэрэгжүүлж Улаанбаатар хотын 21 их, дээд сургуулийн 90 оюутан ажиллалаа.

Оюутан цагдаа нар ажиллах хугацаандаа байгалийн дурсгалт болон түүх соёлын дурсгалт газар, үзвэр үйлчилгээний газрын тухай 7 бүлэг 36 мэдээлэл бүхий QR кодыг гадаадын 6981 жуулчдад танилцуулан мэдээлэл өгч, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 102 тусгай дугаарт гэмт хэргийн 5, зөрчлийн шинжтэй 17 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 7062, гадаадын 7666 жуулчинд үйлчилгээ үзүүлж, 9 төрлийн 11,680 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тарааж, 66 бага насны хүүхдийг ар гэрт нь хүлээлгэн өгөх ажлыг гүйцэтгэсэн.



✓ **Улаанбаатар хотод жуулчин ихээр зорчдог газруудын нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцах ажил**

Гадаад, дотоодын иргэд, жуулчид, аялал жуулчлалын байгууллагуудын санал хүсэлтийн дагуу Улаанбаатар хотод жуулчин ихээр зорчдог газруудын нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулж “Чингис хааны хөшөөт цогцолбор”, “Зайсан толгой- зөвлөлтийн дайчдын цогцолбор”, “Гандантэгчилэн хийд”, “Дашчойлин хийд”, “Дамбадаржаа хийд” болон Горхитэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрлах “Зуун ламын агуй”, “Мэлхий хад”, “Арьяабал бурхан засалч, бясалгалын төв” зэрэг 12 газар очиж ажиллаж, жуулчдыг ая тухтай, аюулгүй аялах нөхцөл боломжоор хангах, гадна, дотно цэвэрлэгээ, өнгө үзэмж,

тохижилт үйлчилгээгээ сайжруулах, нүхэн жорлонг буулгах, стандартын дагуу ариутгал хийж булах, боловсон ариун цэврийн байгууламж байгуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, стандартын дагуу үйлчилгээ эрхлэх талаар заавар зөвлөмж өгч, 4 байгууллагад хийж хэрэгжүүлэх ажлын жагсаалт гарган хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллуулсан.



✓ Жуулчны аюулгүй байдлыг хангах зөвлөмж

Жуулчдын аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гэмт халдлагад өртөх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран "Зөвлөмж" гаргаж "Монголын Аялал жуулчлалын холбоо", "Монголын Зочид буудлуудын холбоо", "Мэргэжлийн тур операторуудын холбоо", "Монголын жуулчны баазуудын холбоо", "Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо" зэрэг 6 мэргэжлийн холбоодоор дамжуулан аялал жуулчлалын тур оператор компани, зочлох үйлчилгээний байгууллагуудад хүргүүлж хамтран ажилласан.




АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУДАД

ЗӨВЛӨМЖ

2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр Улаанбаатар хот

Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөж, холбогдохоос урьдчилан сэргийлэх, тэдний аюулгүй байдлыг хангаж ажиллах зорилгоор дараах зөвлөмж мэдээллийг хүргэж байна. Үүнд:

1. Үйлчилгээний ажилтнууддаа Монгол Улсын хууль тогтоомж, нийтээр дагаж, мөрддөг дүрэм, журмуудын талаар ерөнхий мэдээлэл мэргэжлийн байгууллагатай хамтран өгөх.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Аялал жуулчлалын тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, жуулчны аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар ажилтнууддаа заавар зөвлөгөө өгөх.
3. Гадаад, дотоодын иргэд, жуулчдын эрх зөрчигдсөн гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, мэдээллийг цагдаагийн байгууллагад шуурхай мэдэгдэх.
4. Үйлчилгээний ажилтны ёс зүй, харилцаа хандлагын сургалтыг зохион байгуулж, үйлчилгээний чанарыг сайжруулах.
5. Жуулчдын тээвэрлэлтийн зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлэх.
6. Жуулчдын тээврийн хэрэгслийн камерын хяналтыг сайжруулах, сонор сэрэмжийг дээшлүүлэх.

Жуулчны үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, холбоотой мэдээлэл, гомдол, саналыг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Жуулчны лавлах 7010-8687, гэмт хэрэг, зөрчлийн дуудлагыг Цагдаагийн 102 дугаарын утсанд хандахыг зөвлөе.

НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН
УДИРДАХ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГ ЖУУЛЧЛАЛЫН АГЕНТЛАЛ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
Ж.Самбуурийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/факс: (976) 7011 8687
Цахим шуудан: info@tourism.ub.gov.mn
Цахим хуудас: www.tourism.ub.gov.mn

2023.07.04 № 1/328
тагай -пп № -т

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ХОЛБООНД

Тулгар төрийн 2232, Их Монгол Улсын 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмын өдрүүдэд гадаадын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гэмт халдлагад өртөх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газраас хамтран гаргасан "Зөвлөмж"-ийг хүргүүлж байна.

Цаашид гишүүн байгууллагууддаа гадаадын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэлээр хангаж ажиллахыг зөвлөж байна.

Хавсралт 1 хуудастай.

❖ **Салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулах арга хэмжээ**

Аялал жуулчлалын салбарын байгууллагуудын удирдлага, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр 12 төрлийн 17 удаагийн сургалтыг зохион байгуулж танхимаар 647, цахимаар 2122, нийт 2769 хүнийг хамруулсан. Үүнд:

✓ **“Солонгос хэлний аяллын хөтөч-тайлбарлагч” бэлтгэх сургалт**

Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Солонгос хэлний аяллын хөтөч-тайлбарлагч” бэлтгэх сургалтыг “Гайд” боловсролын төвтэй хамтран 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрөөс 10 хоногийн хугацаанд зохион байгуулж сургалтад 12 аяллын хөтөч тайлбарлагч хамрагдсан.

✓ **“Чингис хаан Үндэсний музейд тайлбар хийх эрх олгох” сургалт**

Аялал жуулчлалын салбарт ажиллаж буй хөтөч, тайлбарлагч нарыг түүх, соёлын өвд суурилсан тайлбарын арга зүйд сургах, музейн үзмэр, эд өлгийн зүйлсийг шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв, ойлгомжтой байдлаар хүргэх, хөтөч тайлбарлагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Чингис хаан Үндэсний музейд тайлбар хийх эрх олгох” сургалтыг Чингис хаан Үндэсний музейтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 21-22, 05 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд 2 удаа зохион байгууллаа.


Сургалтыг Хүннүгийн эзэнт улсаас эхлээд ХХ зууны эхэн хүртэлх Монголын төрт улсуудын хаад, язгууртнуудын эдэлж хэрэглэж байсан бодит эд өлгийн зүйлс дээр тулгуурлан музейн танхимуудад явуулж Монгол Улсын аялал жуулчлалын 35 байгууллагын 96 хөтөч, тайлбарлагч, Белгийн Вант Улс, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орон, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсаас 4 хөтөч, тайлбарлагч буюу нийт 100 хүн хамрагдаж, 2023 оны турш Чингис хаан Үндэсний музейд тайлбар хийх эрхийн үнэмлэх олгосон.



✓ **“Хууль, дүрэм, стандарт” сэдэвт сургалт**

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийг хэрэгжүүлэх

ажлын хүрээнд үндэсний болон хотын стандартуудыг танилцуулах зорилгоор “Монголд зочлох жил”, “Үйлчилгээ эрхлэх бүртгэл-Онлайн бизнес төв”, “Хотын стандартууд”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нь” сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгуулж 5 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын 355 удирдлага хамрагдлаа.



✓ “Оюутан цагдаа-2023” арга хэмжээний сургалт

Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо төрийн бус байгууллага, Улаанбаатар хотын музей, Улаан загалмайн Чингэлтэйн салбар нийгэмлэгтэй хамтран “Оюутан цагдаа-2023” арга хэмжээнд ажиллах оюутнуудын сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгууллаа.

Сургалтыг хууль эрх зүй, жуулчны аюулгүй байдал, Улаанбаатар хотын түүх, соёлын дурсгалт газрууд, хөтөч тайлбарлагчийн ур чадвар зэрэг сэдвүүдийн хүрээнд зохион байгуулж сургалтад 90 оюутан хамрагдлаа.



✓ Сайн дурын хөтөч тайлбарлагч нарт зориулсан сургалт

“Улаанбаатар 2023” Зүүн Азийн залуучуудын наадмын үеэр гаднын орны тамирчид, хүндэт зочдод Улаанбаатар хотыг танилцуулах, хотын хөтчөөр ажилласан сайн дурын ажилтнуудад зориулсан сургалтыг 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж

“Хөтөч, тайлбарлагчдын соёл, ёс зүй, олон улсын стандарт”, “Улаанбаатар хотын түүх соёл, хотын танилцуулга, түүхэн дурсгалт газар, гол үзмэрүүдэд тайлбар хийх нь, “Хууль эрх зүйн мэдлэг олгох нь ” сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгуулж сайн дурын 50 ажилтан хамрагдсан.

✓ **Салбарын бодлого шийдвэр, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаарх сургалт**



Монголд зочлох жилийн хүрээнд аялал жуулчлалын салбарын бодлого төлөвлөлт, чиг хандлага болон шинээр батлагдсан хууль тогтоомжийг танилцуулах, нэгдсэн ойлголт мэдээлэл өгөх зорилгоор нийслэл болон 21 аймаг, 9 дүүргийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан “GO TO MONGOLIA” арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр IBES зочид буудлын хурлын танхимд зохион байгуулав.

“Монгол Улсын аялал жуулчлалын салбарын бодлого, төлөвлөлт”, “Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, чиглэл”, “2024 оны эвент арга хэмжээний нэгдсэн төлөвлөлт”, “Салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт”, “Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлууд”, “Үндэсний экспортын стратеги ба аялал жуулчлал”, “Аялал жуулчлалын статистик тооцох аргачлал” зэрэг сэдвүүдийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдаж нийслэл, дүүрэг, 21 аймгийн нийт 40 албан хаагч хамрагдлаа.



❖ **Цахим сургалтын гарын авлага**

Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, найрсаг үйлчилгээг бий болгох, хотын стандарт болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор үйлчилгээний салбарын ажилтнуудад зориулсан “Угтах үйлчилгээ”, “Зөөгч”, “Өрөө үйлчилгээ”, “Хөтөч тайлбарлагчийн анхан шатны мэдлэг олгох”, “Жуулчин тээвэр, такси үйлчилгээний ажилтнуудын харилцаа хандлага”, “Жуулчидтай харилцдаг төрийн албан хаагчдын харилцаа хандлага” сэдэвт 6 төрлийн цахим сургалтын гарын авлага хичээлийг цахимаар 2122 хүн үзсэн.



1.1.4. “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 7 зорилтын 77 арга хэмжээний биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 80 %-ийн хэрэгжилттэй байна.

1.1.5. “Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

Ковидын дараах нийслэлийн Аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 зорилтын 27 арга хэмжээний биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 80 %-ийн хэрэгжилттэй байна.

ХОЁР.ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.2.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захирамжлалын баримт бичгийн биелэлт:

Байгууллагын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 5 заалтыг хяналтад бүртгэж, 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 91.6%, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 96.33%, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлт 96.25%-ийн хэрэгжилттэй байна.

✓ Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн дүн:

Төрлөөр нь авч үзвэл:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төрөл	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатандаа /50-89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9/	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн дундаж
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэмдэглэл	1	1	1	-	-	-	-	90%
Засгийн газрын тогтоол	2	2	2	-	-	-	-	100%
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2	2	1	1	-	-	-	85.0%
НИЙТ	5	5	4	1	-	-	-	91.6%

✓ Захирамжлалын баримт бичгийн биелэлтийн нэгдсэн дүн:

Захирамжлалын баримт бичгийн төрөл	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатандаа /50-89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9/	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн дундаж
Нийслэлийн Засаг даргын захирамж	30	30	27	2	1	-	-	96.3%
Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл	4	8	7	1	-	-	-	96.25%

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

НЭГ.БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮР ДҮН

2.1.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилтын 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулж, гүйцэтгэлийн тайлан 2023 оны эхний хагас жилийн байдлаар 67.6, жилийн эцсийн байдлаар 94.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж хугацаанд нь тайлагнасан.

Хүснэгтээр үзүүлбэл:

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн тайлан		
Нийт арга хэмжээний тоо		55
1. Бүрэн хэрэгжсэн	90-100 хувь	47
2. Хэрэгжих шатанд	50-89 хувь	7
3. Хэрэгжилт хангалтгүй	10-49 хувь	1
4. Хэрэгжээгүй	0-9 хувь	-
5. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-
Үнэлгээний дундаж хувь		94,3%

ХОЁР.ГАЗРЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ:

2.2.1.Аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;

1.Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/987 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган байгууллагын www.ub.gov.tourism.mn цахим хуудас, газрын facebook хуудсанд “Үйлчилгээ эрхлэх бүртгэл-Онлайн бизнес төв” системийн талаар болон бүртгүүлэх заавар, баримт бичиг, мөрдөгдөж буй стандартуудын талаар байршуулж, аялал жуулчлалын байр сууцаар хангах үйлчилгээ үзүүлдэг 368 аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөгөө мэдээлэл өгч, арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

“Үйлчилгээ эрхлэх бүртгэл-Онлайн бизнес төв” нэгдсэн системд 2022 онд 411, 2023 оны эхний 11 сарын байдлаар 401 нийт 812 (давхардсан тоогоор) аж ахуйн нэгж, байгууллага зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр бүртгүүлж үйл ажиллагаа явуулж байна.

2.“Монголд зочлох жил”-ийн хүрээнд аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд Монгол Улсаа сурталчлах түлхүүр үг “**WELCOME TO MONGOLIA**” зарлаж, аялал жуулчлалын нэгдсэн төлөвлөгөөг танилцуулах нээлтийн арга хэмжээ 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдаж арга хэмжээнд Байгаль орчин аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх, Монголын Аялал жуулчлалын холбооны Ерөнхийлөгч Д.Гантөмөр, Мэргэжлийн тур операторуудын холбооны тэргүүн В.Батзориг, Монголын Зочид буудлуудын холбооны ерөнхийлөгч С.Мөнхбат болон “Хүннү Эйр” ХХК, “Pocket travel” ХХК, “Go nodams tour” ХХК “Номадик трэйлс” ХХК зэрэг байгууллагуудын төлөөллүүд оролцлоо.



3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд гадаад, дотоодын аялагч, жуулчид мод тарих боломжийг бүрдүүлэх, иргэд жуулчид чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжийг бүрдүүлэх “Жуулчин төгөл” бий болгох зорилгоор Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд мод тарих ажлыг 2022 онд эхлүүлж 14 төрлийн 380 гаруй мод, бут тарьж суулгасан.

2023 онд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан “Монгол-Солонгос”-ын аялал жуулчлалын тур операторуудын форумд оролцогч “КТАС” БНСУ-ын жижиг, дунд аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд, Монголын солонгос зах зээлийн тур операторын холбоо болон Монголын Аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд, “Цолмон трэвал” ХХК, Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран мод тарих ажлыг 2 удаа зохион байгууллаа.

“Жуулчин төгөл”-д улиас, монос, шинэс, нохойн хошуу, тэхийн шээг, хавилгана зэрэг нийт 8 төрлийн 230 гаруй мод тарих ажлыг зохион байгуулж нийт 18 төрлийн 510 мод тарих ажлыг зохион байгууллаа.



2.2.2. Аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

1.Монгол Улсын Засгийн газраас 1 сая жуулчин авах зорилт дэвшүүлсэнтэй холбогдуулан зорин ирэх жуулчдыг тоог нэмэгдүүлэх, хүлээн авах бэлтгэл ажлыг эрчимжүүлэх, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын сайд холбогдох албан тушаалтан нар БНСУ, Япон, БНХАУ-аас жуулчин хүлээн авдаг оператор компанийн төлөөлөлтэй мэдээлэл солилцох уулзалтыг 2023 оны 02 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд зохион байгуулав.

Уулзалтад БНСУ, Япон, БНХАУ-ын зах зээл дээр ажилладаг 120 гаруй оператор компанийн төлөөлөл оролцож Монголд зочлох жилийн төлөвлөгөөт ажлын талаар болон жуулчдыг татах олон улсын шинж чанартай эвент арга хэмжээ, жуулчин хүлээн авахтай холбоотой хүндрэл чирэгдлийг арилгах, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг ажлуудын талаар мэдээлэл өгч, санал солилцоо.



2.Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хүрээнд аялал жуулчлалын байр сууцаар хангах үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад салбарын холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, үндэсний болон хотын стандартуудын хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах зорилгоор стандартын үзлэг, хяналт шалгалтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийн хооронд холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 71 дэн буудал, 41 зочид буудал, 131 амралтын газар, жуулчны бааз нийт 243 байгууллага, аж ахуйн нэгжийг стандартын үзлэг, хяналт шалгалтад хамруулж, илэрсэн зөрчилд үндэслэн 20 аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж өгч, Улсын байцаагчийн Албан шаардлагаар хугацаатай үүрэг

даалгаврыг 6 аж ахуйн нэгжид өгч биелэлтийг хангуулан ажилласан бөгөөд зөрчилтэй 3 аж ахуйн нэгжийг тус бүр 500.000 (таван зуун мянган) төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.




3. Аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ буюу амралт газар, жуулчны баазуудад байгальд ээлтэй, инноваци шингээсэн гэр, хаусыг нэвтрүүлэх, шинэлэг өвөрмөц өнгө төрхийг бий болгох, амрагчид болон жуулчдын ая тухтай, аюулгүй амрах нөхцөлийг шинэ шатанд гаргах зорилгоор “Орд гэр” ХХК-аас “Camping and ger Innovation 2023” өдөрлөгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зохион байгууллаа.

Өдөрлөгийн үеэр эко материалаар хийсэн байгаль ээлтэй “Модулан” гэр, “Доум” хаусыг талаар танилцуулга хийж, арга хэмжээнд аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ эрхэлдэг 150 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцлоо.



2.2.3. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах;

1. Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэг, СЭЗИС-ийн Ахисан түвшний сургуультай хамтран “Аялал жуулчлалын статистик ба боломжууд” сэдэвт хэлэлцүүлгийг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж хэлэлцүүлэг “Аялал жуулчлалын салбарын статистик мэдээлэл, хүртээмж”, “Аялал жуулчлалын салбарын статистик мэдээллийн эх сурвалж, боломж” сэдвүүдийн хүрээнд явагдаж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн 30 төлөөлөл, салбарын 20 эрдэмтэн, судлаачид нийт 50 гаруй хүн оролцлоо.



2. Аялал жуулчлалын статистик аргачлалыг боловсронгуй болгох тоон мэдээллийг цуглуулах маягуудыг боловсруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Үндэсний Статистикийн хороо, нийслэлийн Аялал жуулчлалын газар болон аялал жуулчлалын салбарын багш, судлаачдын хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж аялал жуулчлалын статистик үзүүлэлт тооцох аргачлал, статистик мэдээний маягт, түүнийг нөхөх заавар, улирлын мэдээний нэгтгэл хүснэгт зэрэг 9 баримт бичгийн төслийг

боловсруулан Үндэсний Статистикийн хорооны холбогдох шатны хурлаар хэлэлцэн батлуулахаар хүлээгдэж байна.

2.2.4. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;

1. Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Монголын Явган алхалтын холбоотой хамтран Богдхан уулын Зайсан-Дугуй цагаан чиглэлийн 3,6 км урттай явган алхалтын маршрутын дагуу олон улсын стандартад нийцсэн явган алхалтын замын тэмдэг тэмдэглэгээг байршуулахаар ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд явган алхалтын замын олон улсын тэмдэг тэмдэглэгээний стандарт нэвтрүүлэх ёслолын арга хэмжээг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж, арга хэмжээнд Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Ян Вытопил, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх болон Монголын Явган алхалтын холбооны гишүүн клубүүдийн 100 гаруй алхагч нар оролцоо.



2. БНХАУ-ын Соёл, аялал жуулчлалын яам, Хятадын төв радио, телевизээс хамтран "Урлагийн гоо үзэсгэлэн" олон улсын соёлын солилцооны хөтөлбөрийн хүрээнд цайны зам болон соёлын солилцоо, цайны соёлын тухай нэвтрүүлэгт Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга В.Батчимэг оролцож Цайны замын маршрут дагуу авто замын боомтоор Хятад улсаас Монгол Улсад авто машинтай аялах боломжийг танилцуулж оролцлоо.



2.2.5 Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарт соёлын нөлөөллийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2022 оны 03 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсад зохион байгуулах олон улсын арга хэмжээний хуанлийг боловсруулж, олон улсад зарлах үүрэг бүхий дэд ажлын хэсгээс 2023 онд Монгол Улсыг гадаадад сурталчлан таниулах, соёл, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг

сэргээх, эдийн засгийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон улсын чанартай 22 арга хэмжээ, бүс нутгийн 67 арга хэмжээний хуанлийг баталж, Улаанбаатар хотод зохион байгуулах аялал жуулчлалын олон улсын шинж чанартай 6, бүс нутгийн 9 арга хэмжээ нэгдсэн хуанлийд батлагдаж хэрэгжилтийг ханган ажиллалаа.



2. Улаанбаатар хотын түүх соёлын дурсгалт газрууд, хөшөө баримлууд буюу жанжин Д.Сүхбаатарын морьт хөшөөний цогцолбор, Тусгаар тогтнолын хөшөө, Дашдоржийн Нацагдоржийн хөшөөний дурсгал, Зайсан толгой-зөвлөлтийн дайчдын хөшөөт цогцолбор, Монголын Үндэсний музей, Монгол Улсын Төрийн дууллын үг бүхий дурсгал, "Халуун элгэн нутаг" дууны хөшөө, "Богд хааны хөшөө", "Тэмээн жингийн цуваа" зэрэг 21 байршилд Кью Ар /QR/ код бүхий мэдээллийн самбар байршуулж гадаад, дотоодын иргэд, жуулчид 5 хэл дээр (Монгол, Англи, Хятад, Япон, Солонгос) цахим хөтчөөр дамжуулан мэдээлэл авах боломжийг бүрдүүлж мөн <https://ub-places.site> цахим хуудсанд 21 газрын дэлгэрэнгүй мэдээллийг, хаяг байршлын хамт байршуулж олон нийтэд сурталчлан ажилласан.



3. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны түүхт 384 жилийн ойг тохиолдуулан Монголын Явган алхалтын холбоотой хамтран "Соёлтой, эелдэг найрсаг, эрүүл хотын иргэн" уриан дор "I Love UB" иргэдийн явган алхалтын арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж Жанжин Д.Сүхбаатарын талбайгаас Үндэсний цэцэрлэгт хүрээлэн хүртэлх 5 км зайд явган алхалтыг зохион байгуулж нийслэлийн 9 дүүргийн 250 гаруй иргэд оролцлоо.



2.2.6. Нийслэлийн аялал жуулчлалын нөөцөд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах;

1. Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлыг уртасгах зорилгоор “Шинэ жилээр Монголд” хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлтийн аяныг 2022 оны 12 сарын 25-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж, байр сууцны үйлчилгээ, соёл, урлагийн байгууллага, ресторан, зоогийн газар, худалдааны төв зэрэг нийт 200 байгууллага 10-50 хүртэлх хувийн хямдралтай үйлчилгээг иргэд, жуулчдад санал болгож хөнгөлөлт, урамшуулалд хамруулсан. Одоогоор Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 13 амралтын газар 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 20-50 хүртэлх хувийн хөнгөлөлттэй үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүлж байна.



2. Цайны замын олон улсын аялал жуулчлалын холбооны хамтын ажиллагааны хүрээнд Монгол, БНХАУ, ОХУ дамжсан авто аяллыг мэргэжлийн тур оператор байгууллагуудтай хамтран 2023 оны 07 дугаар сараас эхлэн зохион байгуулж Цайны замын дагуу 4 удаагийн авто аялалд нийт 14 мотоцикл, 26 машин бүхий БНХАУ-ын 110 жуулчдыг хамрууллаа.



3. “VISIT ULAANBAATAR” брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, зах зээлд нийлүүлэх зорилгоор “Голден гоби”, “Зүймэл даавуун урлал”, “Хөсөг брэнд”, “Сувинер хаус”, “Тэрэм брэнд”, “Монгол бэлэг” зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллагын 20 нэр төрлийн бүтээгдэхүүнийг туршилтаар гаргаж жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд, хамтран ажилладаг байгууллагуудын худалдааны цэгүүдэд буюу нийт 10 байршилд худалдаанд гаргасан.

“Бүргэдийн баяр-2023”, “Улаанбаатар травэл экспо”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Дээлтэй Монгол наадам”, “Хүрээ цам-даншиг наадам”, “UB food фестиваль”, “Хийморь” морьт харвааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зэрэг 7 арга хэмжээний үеэр давхардсан тоогоор 488 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний худалдааг гарган 610,211,000 (зургаан зуун арван сая хоёр зуун арван нэгэн мянга) төгрөгийн борлуулалт хийж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан.

4. “Сити тур” төслийг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлж нийт 45 удаагийн аялалд 5052 гадаад, дотоодын иргэн, жуулчдыг хамруулж Улаанбаатар хотын аяллыг зохион байгууллаа.



ГУРАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн шийдвэрлэлт

2.3.1. Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хариутай 131, хариугүй 539 нийт 670 албан бичгийг бүртгэж, 540 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу боловсруулан явуулсан. Ирүүлсэн 670 албан бичгээс 659 албан бичгийг эцэслэн шийдвэрлэж, 11 албан бичиг судалж байгаа төлөвтэй албан бичгийг 99.33%-тай шийдвэрлэсэн.

2.3.2.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2022 оны байнга хадгалах 60, түр хадгалах 67, 70 жил хадгалах 3, тусгай төрлийн 27 нийт 157 баримтыг архивд хүлээн авч архивын баримтын нэгдсэн данс бүртгэл хөтөлсөн.

✓ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

2.3.3. Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 32 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100% эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 00 цаг 49 минут байна.

✓ Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн үйл ажиллагаа

2.3.4.Жуулчны мэдээлэл, сурталчилгааны 7 төвөөр 2023 онд 10,741 гадаад, дотоодын иргэн. жуулчин үйлчилгээ авч, “Бүргэдийн баяр”, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” арга хэмжээ болон “Улаанбаатар травел экспо” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, “ITM Mongolia-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зэрэг арга хэмжээний үеэр жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн цэгийг ажиллуулж 30,000 хүн нийт 40,741 гадаад, дотоодын иргэн., жуулчдад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ:

НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨСӨВ САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

✓ Төсөв, санхүүгийн ил тод байдал

3.1.1. Байгууллагын 2023 оны төсөвт бичиг хэргийн зардалд 1,466,000 төгрөг, тээвэр шатахууны зардалд 7,708,800 төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 4,800,000 төгрөг нийт 13,974,800 батлагдаж 2023 оны эхний 11 сарын байдлаар бичиг хэргийн зардалд 1,374,140 төгрөг, тээвэр шатахууны зардалд 5,593,550 төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 3,708,883 төгрөг нийт 10,676,573 төгрөг зарцуулсан. Санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

3.1.2.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд эвент арга хэмжээ зохион байгуулахад 662,034.0 төгрөг, томилолт, хурал, зөвлөгөөн, уулзалт зохион байгуулахад 89,941.9 төгрөг, маркетинг, сурталчилгаа, хамтын ажиллагааны чиглэлээр 440,042.5 төгрөг нийт 1,192,019,435 (нэг тэрбум нэг зуун ерэн хоёр сая зуун арван есөн мянга дөрвөн зуун гучин тав) төгрөгийг батлуулж, санхүүгийн баримтын бүрдлийг ханган тайлагнасан.

3.1.3.Шилэн дансны тухай хууль холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж байгууллагын жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн тайлан, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд тайлагнаж 2023 оны эхний 11 сарын байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 46, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр 22, бусад чиглэлээр 61 буюу 129 ажил, арга хэмжээний мэдээ мэдээллийг www.info.shilendans.gov.mn цахим санд оруулж ил тод байдлыг ханган ажилласан.

3.1.4.Байгууллагын 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих төсвийн орлогын төлөвлөгөөг бүрэн хангаж, “Сити тур” төслийг 2023 оны 05 сараас 10 сарын хугацаанд хэрэгжүүлэн 30,081,000 (гучин сая наян нэгэн мянга) төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

✓ **Худалдан авах ажиллагааны ил тод байдал:**

3.1.5. Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аялал жуулчлалын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний хүрээнд Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны булш” цогцолборын тохижилтын ажлын нийт санхүүжилт 672,141,955 (зургаан зуун далан хоёр сая нэг зуун дөчин нэгэн мянга есөн зуун ерэн тав) төгрөг үүнээс 2022 онд 348,700,000 (гурван зуун дөчин найман сая долоо зуу мянга) төгрөг, 2023 онд 170,000,000 (нэг зуун далан сая) төгрөгийн санхүүжилтийг захиалагч талаас ажлын гүйцэтгэлээр олгосон.

✓ **Хүний нөөцийн ил тод байдал:**

3.1.6. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын бүтэц, орон тооны хязгаарыг 18 албан хаагчтай, Захиргаа, санхүүгийн хэлтэс, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс гэсэн 2 зохион байгуулалтын нэгжтэйгээр баталсан бөгөөд Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн хүрээнд удирдах албан тушаалын 1, гүйцэтгэх албан тушаалын 2 нийт 3 албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг хүргүүлэн тусгай сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн албан хаагчдаас сул орон тоог нөхөх ажлыг ажлыг зохион байгууллаа. Төрийн үйлчилгээний албан тушаалд 3 албан хаагч, Хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр 2 албан хаагчийн томилон ажиллуулсан.

3.1.7.Авлигаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн тайлагнах арга зүйн сургалтад 17 албан хаагчийг хамруулж, эрх бүхий албан тушаалын 3 удаагийн сургалтад Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтнийг хамруулж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд 14 албан хаагч хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлгээ тайлагнаж, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн дүгнэлтийг үндэслэн удирдах албан тушаалд 1, гүйцэтгэх албан тушаалд 5, нийт 6 албан хаагчийг томилсон.

3.1.8.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1 дэх заалтын дагуу “Тушаалын төслийн саналын хуудас”-ыг газрын дарга, хэлтсийн дарга нараар тухай бүрд нь бөглүүлж, ашиг сонирхлын зөрчилтэй, эсэх мэдэгдлийг гаргуулан ажиллаж байна. Тус хуулийн 8.2. дахь заалтын дагуу албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий

байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдсэн, энэ хуулийн 29.2.2. дахь заалтыг зөрчсөн албан хаагч байхгүй болно.

3.1.9.“Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд Хүний нөөцийн нэгдсэн системд албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний өөрчлөлт мэдээллийг тогтмол оруулан холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд шинээр 1 албан хаагчид зэрэг дэв олгуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 6 албан хаагчид шинэчлэн олгож, 1 албан хаагч төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн.

✓ **Мэдээллийн ил тод байдал:**

3.1.10.Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээлэл байгууллагын зорилго зорилт, үндсэн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, албан хаагчдын мэдээлэл, төрийн үйлчилгээ болон хүний нөөц, санхүүгийн ил тод байдал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол шинэчлэн ажилласан.

3.1.11.Байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn, www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд 2023 онд давхардсан тоогоор 2382 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 1,699,106 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан.. Тухайлбал:

- www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 749 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 245,000
- www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 179 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 54,755
- <https://www.facebook.com/UlaanbaatarTourism> цахим хуудсанд 1248 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 29,248 хандалтын тоо 1,247,550
- <https://www.instagram.com/visit.ulaanbaatar/> цахим хуудсанд 117 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 311, хандалтын тоо 92,577
- <https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA> цахим хуудсанд 89 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 342, хандалтын тоо 59,224 байна

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН:

✓ **Нэгдсэн арга хэмжээ**

4.1.1.“Хүний хөгжил, нийгмийн хөгжил” сэдэвт нийслэлийн нийгмийн салбарын байгууллагуудын нэгдсэн өдөрлөг, Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Нэгдүгээрт хүүхэд” уриа дор зохион байгуулагдсан “Монгол хүүхдүүд” арга хэмжээ, “Иргэдэд ээлтэй стандарт” өдөрлөг зэрэг нэгдсэн 4 арга хэмжээнд жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг ажиллуулж давхардсан тоогоор 2500 гаруй сурталчилгааны материал тарааж, 5000 гаруй хүнд мэдээ, мэдээлэл өгч байгууллагын үйл ажиллагаа танилцуулан оролцсон.

4.1.2.“Эрх зүйн шинэчлэл”, “Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Монголд зочлох жилийн хүрээнд 2023 оны олон улсын болон бүс нутгийн арга хэмжээний хуанли боловсруулах нь”, “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн хэлэлцүүлэг, “Улаанбаатар-олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум”, Улаанбаатар хот ЮНЕСКО-гийн “Бүтээлч хотуудын сүлжээ”-нд элссэн арга хэмжээ,

"Аялал жуулчлалын салбарын эрхзүйн шинэчлэл", "Аялал жуулчлалын статистик аргачлалыг боловсронгуй болгох нь" сэдэвт уулзалтууд, "Хүн бүр байгаль хамгаалагч" зөвлөгөөн, "Жорлон" Үндэсний чуулган зэрэг олон улс, үндэсний болон бүс нутгийн 12 арга хэмжээнд оролцлоо.



4.1.3. Дэлхийн аялал жуулчлалын өдрийг тохиолдуулан Монголын аялал жуулчлалын холбоо, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Боловсролын газар хамтран хүүхэд багачуудын аяллын боловсролыг дээшлүүлэх, байгаль орчин, хүрээлэн буй орчноо хамгаалах, зөв зохистой ул мөргүй аялах, бага насны хүүхдүүд аялахдаа эзэмшвэл зохих суурь мэдлэг олгох зорилгоор "Ногоон хөрөнгө оруулалт бидний ирээдүй" уриа дор "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад аяллын боловсрол олгох сургалт өдөрлөг"-ийг 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж Монголын аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллага "Жуулчин" ХХК, "Монголиа Воаяж" ХХК, "Цолмон Трэвел" ХХК, "NoNa Family" ХХК, "Golden stirap" ХХК, "Boojum Expeditions" ХХК, "ДМД Монгол" ХХК зэрэг байгууллагууд нийслэлийн 7 дүүргийн ЕБ-ын 20 сургуулийн 5 дугаар ангийн 2500 гаруй сурагчдад сургалт орж, аяллын талаар мэдээлэл өглөө.





4.1.4. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэгтэй хамтран “Grand tour-2023” аялал жуулчлалын улсын XXI олимпиадыг “GREEN INVESTMENT TOURISM – WELCOME TO MONGOLIA” уриа дор 2023 оны 09 дүгээр 19-27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Олимпиадыг танин мэдэхүйн “Центавр” асуулт хариултын тэмцээн, “Grand tour” спорт явган алхалтын тэмцээн, “Cesim service” загварчлалын тэмцээн, оюутны эрдэм шинжилгээний бага хурал зэрэг 5 төрлөөр зохион байгуулж аялал жуулчлалын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг 14 их, дээд сургууль, коллежийн 400 орчим оюутнууд оролцлоо. Хаалтын арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж “Welcome to Mongolia” аялал жуулчлалыг сурталчлах өдөрлөг зохион байгуулж амжилттай оролцсон сургууль болон оюутнуудад шагналыг гардуулах ёслолын арга хэмжээ зохион байгуулагдлаа.



4.1.5. Аялал жуулчлалын салбарт ажиллах сонирхолтой оюутан залуус, иргэдийг эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу түр болон байнгын ажлын байртай болгох, аялал жуулчлалын байгууллагуудад шаардлагатай ажилтнаа олоход нь дэмжлэг үзүүлэх, ажил


олгогч, ажил хайгч иргэдийг холбох зорилгоор "Аялал жуулчлал ба ажил эрхлэлт" хөдөлмөрийн яармаг арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр "ITM Mongolia-2023" (International Travel Mart) олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр зохион байгууллаа.

"Аялал жуулчлал ба ажил эрхлэлт" хөдөлмөрийн яармагт аялал жуулчлалын 37 байгууллагын байнгын болон түр 183 ажлын байр зарлагдаж 67 ажил хайгч иргэнийг ажилд зуучлав.




4.1.6. “Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулийн Шуурхай удирдлагын төв штабын хангалтын багт нийслэлийн Аялал жуулчлалын газраас 1 албан хаагч ажиллаж шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгааг бэлтгэн ажиллаж, стратегийн команд штабын сургуулийн хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж, аюулгүй талбайд цугларах дадлага, сургуульд нийт албан хаагчид хамрагдсан.

Мөн Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагын харилцан ажиллагаа” сэдэвт стратегийн команд штабын сургуулийн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдад газар хөтлөлт, гал түймрээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг хохирол багатай даван туулах, тохиолдсон үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах талаар мэдлэг олгох зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах, тохиолдсон үед авах арга хэмжээ” сэдэвт танхимын сургалтад 17, биет сургалтад 11 албан хаагч хамрагдсан.



4.1.7. Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2023 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний хуваарь батлах тухай” А/01 дүгээр тушаалын хүрээнд бүх нийтийг хамарсан 6 удаагийн их цэвэрлэгээний ажилд хуваарийн дагуу нийт албан хаагчид оролцлоо.



4.3. Нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавьж, мэдээлэл өгч ажиллах байгууллага, албан тушаалтны хуваарь”-ийн дагуу 2022 оны 12 сараас 2023 оны 03 дугаар сарыг дуустал хугацаанд Чингэлтэй дүүргийн 17, 18 дугаар хороодын сайжруулсан шахмал түлшний 12 борлуулалтын цэгт тогтмол хяналт тавьж, хороодын Засаг даргын ажлын албатай хамтран эрсдэл бүхий айл өрхөөр орж зуух, пийшингийн аюулгүй байдлыг хангах, зөв галлагааны талаар заавар, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж ажилласан.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ

